

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	2024 онд төвийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилгыг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд 6 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж, төлөвлөгөө биелэлт 98,3 хэрэгжсэн байна.	
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Үндсэн чиг үүрэг: Улсын хэмжээнд Зоонозын өвчнийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Төв нь Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/305 дугаар тушаалаар батлагдсан дүрэм, бүтцийн дагуу 7 албатай үйл ажиллагаа явуулж байна. Хаяг байршил: Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо. Улаанбаатар 18131 Утас: 70282853 Цахим хаяг: https://nczd.gov.mn/	100
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	Төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх биелэлтийн тайланг боловсруулан www.shilendans.gov.mn , төвийн www.nczd.gov.mn сайтуудад хуулийн хугацаанд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.	100
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Төвийн чиг үүргийн хүрээнд дагаж мөрддөг 32 хууль эрх зүйн актын хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн.	100
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Төвийн үндсэн чиг үүрэгт хамаарах арга хэмжээнүүдийн хэрэгжилт 100% хэрэгжин тайлан бичигдсэн. Үүнд: Алсын хараа” – 2050 - 5 арга хэмжээ Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан- 15 арга хэмжээ Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан - 9 арга хэмжээ	100
1.6	Үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр,	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн албан ёсны http://www.nczd.gov.mn/ цахим хаягт Хууль, эрх зүй цэсийн Төвийн ерөнхий захирлын тушаал буланд	100

	бусад эрх зүйн акт	2023 оны захирлын тушаалын товъёгийн жагсаалт, хүний нөөцийн үйл ажиллагаанд мөрдөгддөг дүрэм, журам, тушаал, байгууллагын орон тоо, бүтцийн тушаалыг тус тус олон нийтэд ил тод нийтэлсэн. Мөн төвийн дотоод сүлжээнд тушаал шийдвэр, заавар, журмыг ажилтан, албан хаагчдад нээлттэй байршуулж, тухай бүр шинэчлэн, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол хариуцсан ажилтан: Хүний нөөцийн менежер Э.Пагмадулам. Албаны харилцах утасны дугаар 70282853 Цахим хаяг nczd@nczd.gov.mn	100
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	Тайлангийн хугацаанд тус төвд 2 иргэнээс өргөдөл гомдол ирүүлснийг шийдвэрлэн ажилласан. Үүнд: 11-11 төвд гаргасан гомдол-1, иргэнээс бичгээр ирүүлсэн өргөдөл гомдол-1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн, иргэдэд албан бичгээр хариуг хүргүүлсэн. Төвийн албан ёсны веб хуудсаар иргэдээс гомдол мэдээлэл, санал авах тусгай буланг ажиллуулж, нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Тус төв нь 2024 онд мэрэгчийн 316 удаагийн дуудлага, хүний өвчлөлийн 968 сэжигтэй дуудлагад үйлчилсэн байна.	100
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Иргэд, олон нийтэд зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл хүргэх үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгууллаа. Танхимийн сургалт мэдээлэл: 1. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт боомтод ажилладаг ЭАХХУ-ын байцаагч нар болон боомтын 20 ажилчинд тарваган тахал өвчний тархвар судлал, хариу арга хэмжээний талаар сургалт хийв. 2. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хийгдсэн тандалт судалгаагаар тус суманд оршин суудаг 80 гаруй иргэд, Баян-өлгий аймагт хийгдэж буй тандалт судалгааны хүрээнд 100 гаруй өрхөд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа хийсэн. 3. Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн зарим сумдад хийгдсэн тандалт судалгаагаар 85 иргэдэд хачигт халдвар болон шумуулаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас тарааж мэдээлэл хийсэн. 4. Тарваган тахал өвчний тархвар судлал, хариу арга хэмжээний талаар яаралтай тусламж 103-ын эмч мэргэжилтэнүүдэд танхимын сургалт зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн яаралтай тусламжийн 150 гаруй эмч мэргэжилтэн хамрагдсан. 5. БНӨС улсад НҮБ-ын мандаттай UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн	-

Монгол Улсын Зэвсэгт хүчний 013, 150 дугаар ангийн 674 энхийг сахиулагч нарт 4 удаа Хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг хүргэж сургалт зохион байгуулсан.

Телевизийн ярилцлага:

1. ТМ, Дорнод, Сүхбаатар, Eagle, UBS, NTV, C1, Монгол, TV25, Tenger Tv, МҮОНТВ-д галзуу, хачгаар дамжих халдвар, боом, тарваган тахал өвчний нөхцөл байдлын болон урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл 19 удаа хийсэн байна.

2. Экологийн цагдаагын алба, ЗОС ФИЛЬМ МЕДИА ГРУПП ХХК-тай хамтран Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 3 видео контент бэлтгэн нийтэлсэн.

Радио ярилцлага:

МҮОНР эрүүл мэндийн нэвтрүүлэг, Баян-өлгий радио телевизэд тус төвийн эмч, мэргэжилтнүүд оролцож малчид, ард иргэдэд 3 удаагийн зоонозын өвчний мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлэг өгсөн байна.

Цахим сүлжээ:

1. Цахим хуудас: 203 мэдээ нийтэлсэн. Нийт хандалт 186670 байна.

2. Олон нийтийн сүлжээ: 418 мэдээ нийтэлсэн. Нийт 298181 гаруй хандалттай байна. Тарваган тахал, галзуу, боом, анзаарагддаггүй халдварт өвчин, бэтэг өвчнүүдээс сэргийлэх, эрсдэл өртсөн үед авах арга хэмжээ болон гамшгийн үеийн буюу үерийн үед зоонозын халдвараас сэргийлэх мэдээ мэдээллийг түлхүү хүргэж ажиллаж байна.



3. Төвийн фэйсбүүк хуудасны мессенжерт 24/7 горимоор ажиллах чатбот 24/7 горимоор ажиллан 84 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.


4. Мэдээллийн сайт: isee.mn, gogo.mn, mnb.mn, itoim.mn, news.mn, eagle.mn, news.mn, ikon.mn, Zugii.mn, Tsahiur.mn, Zarig.mn, Өдрийн сонинд ярилцлага мэдээлэл өгсөн сайтуудад тарваган тахал, боом, галзуу, хачгаар дамжих халдвар, хумхаа өвчнөөс сэргийлэх, зудын болон шар усны үерийн үед үүсэж болзошгүй зоонозын халдвар, тэдгээрээс хэрхэн сэргийлэх, үерийн дараах халдваргүйжүүлэлтийн талаар 32 ярилцлага, мэдээлэл өгсөн.


Шинээр боловсруулсан инфографик, постер: Анзаарагддаггүй халдвар -26, Зоонозын халдварт өвчний тухай-1, Денги-1, Боом-2, Бруцеллөз-1, Хачгаар дамжих халдвар-3, Халдваргүйжүүлэлт - 6, боом өвчний тухай видео-1, постер-1 Галзуу-1, Сармагчингийн цэцэг-1 контент шинээр боловсруулан цахим мэдээллийн хэрэгслээр хүн амд хүргэсэн.

Анзаарагддаггүй өвчнүүдийн дэлхийн өдөр: 2024 оны 01 сарын 30-ны өдөр “Нэгд, Хий, Устга” уриан дор анзаарагддаггүй өвчнүүдийн дэлхийн өдрийг зохион байгуулсан. Үүнд:

5. МҮОНР-аар хүн амд анзаарагддаггүй өвчнүүдийн дэлхий дахинд болон монгол улс дахь өнөөгийн нөхцөл байдал, сэргийлэлт, хариу арга хэмжээний талаарх мэдээлэл хүргэсэн. Мөн ярилцлага www.mnb.mn, www.egel.mn мэдээллийн сайтуудад нийтлэгдэв.

		<p>6. Анзаарагддаггүй өвчнүүдийн мэдээлэл бүхий 24 инфографик шинээр боловсруулан, нийтлэв. Хумхаа өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр: 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Эрх тэгш, шударга нийгмийг бүтээхийн төлөө хумхаа өвчний эсрэг тэмцлийг эрчимжүүлье” уриан дор хумхаа өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлээ. Үүнд: 7. Төвийн цахим хуудас, Эрүүл мэндийн яам болон төвийн олон нийтийн сүлжээгээр хумхаа өвчинтэй тэмцэх өдөр, урьдчилан сэргийлэлт, мэдээ мэдээллийг хүргэсэн. 8. “Хумхаа өвчний хяналт, сэргийлэлт” сэдвээр ЭМЯ-ны хэвлэл мэдээллийн төвөөс лайв, News.mn мэдээллийн сайт, МҮОНП-аар иргэд, олон нийтэд хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Зэвсэгт хүчний 013, 150 дугаар ангийн 112 ажилтан, алба хаагчид танхимын сургалт зохион байгуулсан. 9. Галзуу өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр: 2024 оны 09 дүгээр сарын 28-нд Галзуу өвчинтэй тэмцэх Дэлхийн өдрийг тохиолдуулан Дэлхийн Галзуу өвчний эсрэг өдрийг тохиолдуулан Бид галзуу өвчнөөс 100% урьдчилан сэргийлж чадна уриатайгаар видео контент, урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий дотууд төвийн албан ёсны цахим хуудсаар нийтлэв.</p>	
Хэсгийн дундаж хувь:		 <p>ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ</p> <p>2018 оны 10 сарын 24 өдөр</p> <p>Др. А. А. А. А.</p> <p>Улаанбаатар хот</p> <p>Журам батлах тухай</p> <p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, 4.2.4 заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1, 130.2, Төвийн хөдөлмөрийн дотоод журмын 2.1- 2.11 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:</p> <p>1. "Төрийн алба ил тод байх", "Иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх" зарчмыг хэрэгжүүлж ажиллах зорилгоор "Шинэ ажилтан сонгон шалгаруулах, ажигд авах, дадлагажуулах журам"-ыг хэвсрэлтээр баталсугай.</p> <p>2. Журмын хэрэгжилтийг ханган ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн чадварлаг хүний нөөцийн бүрдүүлэлт хийхэд анхаарч ажиллахыг Захиргаа төлөвлөлт, хүний нөөц, статистикийн албаны дарга /Б. Амгаланбаяр/-д үүрэг болгосугай.</p> <p>3. Энэхүү тушвалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, хяналт, үнэлгээ, дотоод аудитын албаны дарга /З. Тунгалаг/-д даалгасугай.</p> <p>ЗАХИРАЛ  ИЦОГБАДРАХ</p>	*****
Хоёр: Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээл			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<p>Зоонозын өвчин судлалын үндэсний сайдын 2023 оны А/305 дугаар тушаала 110 орон тоотойгоор үйл ажиллагаагаа сүүлийн жилд бүрэн гүйцэтгэж, Үүнээс Хуулийн зөвлөх, Дотоод ажилтан, Биотехнологич, Генетикч-судлаач, Сургалтны орон тоо байна. Сул орон тоонд ажилтан сонгон шалгаруулах албан ёсны веб хуудсан тухай бүр байрны мэдээлэл ил тод байна.</p>	100
2.2	Албан хаагч, ажилтны сонгон шалгаруулах журам	<p>Төвийн Ерөнхий захирлын 2018 оны “Шинэ ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах, дадлагажуулах журам” батлах тухай А/74 дүгээр тушаалын дагуу сул орон тооны сонгон шалгаруулалтыг явуулж, хүний нөөцийг бүрдүүлж байна. Сул орон тооны мэдээллийг төвийн албан ёсны цахим хуудас болон олон нийтийн сүлжээн дэх фэйж хуудсаар дамжуулан давхардсан тоогоор 31 удаа ажлын байрны зар байршуулан, нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын журмаар 15 ажилтан шинээр ажилд авсан байна.</p>	100
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	Эрүүл мэндийн сайдын 2019 оны 9 сарын 4-ний өдрийн А/406 дугаар тушаалаар	100

		<p>батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” болон ЭМС-ын 2017 оны Дүрэм батлах тухай А/256 дугаар тушаалаар батлагдсан Ёс зүйн салбар хорооны ажиллах журмыг төвийн цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Дээрх ёс зүйн дүрмийг сурталчилах, байгууллагад эерэг соёлыг төлөвшүүлэхээр Ёс зүйн салбар хорооноос бүх ажилтнууд болон 2024 онд шинээр ажилд орсон эмч, ажилтнуудын дунд 3 удаагийн сургалт, уулзалтыг зохион байгуулсан.</p> 	
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	<p>Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2024-2027 он/-ийг төвийн Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, төвийн Захирлын 2024 оны А/71 дүгээр тушаалар батлуулан, хэрэгжүүлж байна. Батлагдсан хөтөлбөрийг төвийн веб хуудсанд байршуулсан.</p>	100
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр гарсан тушаал, удирдамж, хөтөлбөрийг төвийн албан ёсны цахим хуудаст байршуулсан. Мөн байгууллагын бүтэц, дүрмийг цахим хуудсанд байршуулдаг бөгөөд сул ажлын байр гарсан тухай бүр нээлттэй сонгон шалгаруулах зарыг цахим болон веб хуудсанд байршуулж байна.</p>	100

		<p>Шилэн дансны хууль, холбогдох тогтоол, журмын дагуу байгууллагын цахим хуудасны ил тод байдал цэсэнд:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагаа - Ёс зүйн хороо - Хүний нөөц - Авилга - Төсөв санхүү - Худалдан авах ажиллагаа зэрэг мэдээллийг ил тод олон нийтэд мэдээлж байна. <p>Шилэн дансны цахим программд хүний нөөцийн мэдээллийг хугацаанд нь мэдээллэж байна.</p>	
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	<p>Төвийн Захирлын 2021 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан журмыг боловсронгуй болгох зорилгоор нийт ажилтан албан хаагчдаас санал авч, Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн 2023 оны А/38-р тушаалаар журмыг шинэчлэн баталсан. Уг журмаар нийт ажилтан, албан хаагчдад олгох үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, мөн оны шилдэг ажилтан шалгаруулах үнэлгээний шалгуурыг илүү боловсронгуй болгож, мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>Уг журмаар ажилтан, албан хаагчид сар, улирал бүр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлүүлэн, үнэлгээний дүнг цалин урамшуулалтай уялдуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - “Мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу улирал бүр ажилчдын ажлыг дүгнэн, нэгдсэн үнэлгээг УЗХурлаар 4 удаа хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан давхардсан тоогоор 350 гаруй ажилтанд 111,630,000 гаруй сая төгрөгийн урамшуулал олгосон байна. - “Ур чадвар олгох журам”-ын дагуу сар бүр ажилчдын ажлыг дүгнэн, нэгдсэн үнэлгээг УЗХурлаар 11 удаа хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан давхардсан тоогоор 980 гаруй ажилтанд 115,440,00 гаруй сая төгрөгийн урамшуулал олгосон байна. 	100
Хэсгийн дундаж хувь:			100
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн	2023 он 2.916.1 сая төгрөгийн төсөв батлагдаж төсвийн гүйцэтгэл, санхүүгийн	100

	жилийн төсөв, дараа оны төсвийн төсвийн төсөл	тайлан өр авлагагүй тайлагнасан.2024 оны байдлаар 4,749.7 сая төгрөгийн төсөв батлагдсан. 2024 оны 1-р сарын байдлаар нийт 31.6 сая төгрөгийн ХХОАТ, НДШ, түлш халаалтын зардлын өр үүссэнийг 2024 оны батлагдсан төсөвтөө Сангийн сайдын 73-р тушаалын хавсрал-1 “зардлын бүлэг хооронд шилжүүлэх” хийлгэх саналыг ЭМЯаманд удаа дараа албан тоотоор хүргүүлснийг үр дүнд 30.55 сая төгрөгийн өрийг барагдуулж, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар 1.05 сая төгрөгийн өртэй санхүүгийн тайлан гарсан. Жилийн эцэст өр үүсэх магадлалтай зардлын тооцооллыг хийж албан тоотоор ЭМЯ болон Сангийн яаманд албан тоотоор санхүүжилт хүссэний үр дүнд 64.5 сая төгрөгийн санхүүжилт шийдэгдэж 2024 оны жилийн эцсийг өр, авлагагүй тайланг гаргаж байна.2025 онд 5,264,8 сая төгрөгийн төсвийн төслийг боловсруулсан ба нэн шаардлагатай хэд хэдэн зардлын ангиллыг нэмэгдүүлж тооцоолсон.	
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	2023 оны жилийн санхүүгийн тайлан, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn сайт болон төвийн www.nczd.gov.mn вэб сайтуудад байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.	100
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2023 оны жилийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын шалгалтын дүгнэлтийг бүрэн эхээр нь хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn сайт болон төвийн www.nczd.gov.mn вэб сайтуудад байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.	100
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Тус төв нь хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамжгүй болно. Сар бүр www.shilendans.gov.mn сайтад оруулах мэдээлэл бахгүй тухайгаа мэдээлсэн.	100
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Сар бүр www.shilendans.gov.mn сайтад төсвийн гүйцэтгэлийн тайланг сангийн яамны и-хуулга системээс татаж мэдээлэл байршуулсан	100
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг	Шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш худалдан авалт хийгдсэн гүйлгээг тухай бүрт мэдээлж ажиллаж байна.Мөн байгууллагын ил тод хэсэгт давхар байршуулсан. Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий зардлуудыг худалдан авалтын хэсэгт дахин оруулж мэдээлдэг ба сарын гүйлгээ хийсэн зарлагын дүн таван саяас дээш гүйлгээг мөн шилэн дансанд мэдээлж байна. Байр ашиглалттай холбоотой зардлын гүйлгэ Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан зардлын гүйлгэ Нормын хувцас худалдан авсан зардлын гүйлгээ	100

		Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд гүйлгээг тус тус шилэн дансанд мэдээлсэн байна.	
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг сар бүр шилэн дансанд мэдээлэн ажилладаг.Сангийн яам сар бүрийн орлогын хуваарийн гүйлгээг хийсэн даруйд шилэн дансанд мэдээлдэг ба 14 орлогын гүйлгээг мэдээлсэн мөн төсөл хөтөлбөрийн хүрээнд 6 орлогын гүйлгээг мэдээлсэн байна. Байр ашиглалттай холбоотой зардлын гүйлгээ Эм,эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан зардлын гүйлгээ Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлын гүйлгээ Нормын хувцас худалдан авсан зардлын гүйлгээ Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд зардлын гүйлгээг шилэн дансанд тус тус байршуулсан.	100
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Төвийн захирлын зардал батлах тушаалуудыг шилэн дансанд мэдээлсэн ба нийт 13 төрлийн тушаал шийдэр байна.Үүнд 2024/02/13 A06, 2024/03/30 A15, 2024/04/09 A19, 2024/05/06 A26, 2024/05/15 A27, 2024/05/20 A30,31, 2024/06/04 A32, 2024/07/04 A43,44, 2024/08/13 A49, 2024/10/16 A60, 2024/10/24 A61	100
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	2023 оны аудитын тайлангийн зөвлөмжөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хуулийн хугацаанд нь www.shilendans.gov.mn сайтад байршуулсан.	100
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ЭМЯ болон СЯ батлуулж Tender.gov.mn сайтад байршуулсан. 1. “Урвалж оношлуур химийн бодис,тэжээлт орчин нийлүүлэх” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахаар төлөвлөсөн нийт 367.650.000 төгрөгийн төсөвт өртөгтэй зарласан.Төвийн захирлын А/17 тоот тушаалаар үнэлгээний хороог томилсон.Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заагдсан төсөвт өртгийг үндэслэн	100


<p>шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан</p>	<p>сангийн сайдын А/258 тушаал тендер шалгаруулалтын жишиг баримтын дагуу оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт боловсруулсан.Тендерийн урилгыг нээлттэй тендер шалгаруулалтын арга,Гэрээ шууд байгуулах аргаар нийт 5 удаа нийтэлсэн.2024 оны 04 дүгээр сарын 17 ний өдөр зарлагдсан тендерт нийт 4 багцтай зарлагдсан Багц-2 Молекул биологийн оношлуурын багцад 3 оролцогч материал ирүүлсэн Аглагмед ХХК-ны ирүүлсэн тендерийн төсөвт өртгөөс хэтэрсэн тул татгалзсан.Монветмед ХХК-ны ирүүлсэн тендер шаардлагад нийцсэн тендерээр шалгараагүй.Антиген ХХК-ны ирүүлсэн тендер хамгийн сайн тендерээр үнэлгээний хороо шалгаруулж захиалагчид зөвлөмж хүргүүлсэн ба гэрээ байгуулах эрх олгосон бусад багц амжилтгүй. 2024 оны 05 дугаар сарын 23 өдөр нийт 3 багц болгон зарласан Багц-1 Ийлдэс судлалын оношлуур-Сетунари ХХК-ны ирүүлсэн тендер төлөвлөсөн төсөвт өртгөөс хэтэрсэн тул тус тендерээс татгалзсан.Бусад багц амжилтгүй зохион байгуулагдсан. Төвийн оношлуурын нөөц дууссан байнгын бэлэн байдлыг хангах боломжгүй нөхцөл байдлын үүссэн ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйл Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхээр үнэлгээний хороо шийдвэрлэн гэрээ шууд байгуулах хэлэлцээрийн зарлалыг байгууллагын ил тодод байршуулсан.</p> <p>Хэлэлцээрт оролцох сонирхлоо илэрхийлсэн оролцогчидтой цахим хурал хийж хурлын дэгийг оролцогчдод танилцуулж Хэлэлцээгээр техникийн тодорхойлолт, санхүүжилтийн болон гэрээний нөхцөлийн талаар мэдээллийг солилцсон хэлэлцээрт оролцсон оролцогч орох эрхтэйгээр 2024 оны 06 сарын 28-ны өдөр 5 багцаар тендерийн урилгыг нийтэлсэн.Багц-1 Ийлдэс судлалын оношлуур нийлүүлэхээр Сетунари ХХК-ны ирүүлсэн тендер хасгийн сайн тендерээр шалгарсан.Багц-2 Нян судлалын оношлуур нийлүүлэхээр Аглагмед ХХК оролцсон ба хамгийн сайн тендерээр шалгарсан. Багц-3 тэжээлт орчин түргэвчилсэн тест нийлүүлэх тендерт Монветмед ХХК-ны ирүүлсэн тендер хамгийн сайн тендерээр шалгарсан.Багц-4,5 амжилтгүй зохион байгуулсан.2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр урилгыг дахин 3 багц болгон нийтэлсэн ба тендерийн нээлт хийхэд оролцогчгүй амжилтгүй болсон. 2024 оны 09 дүгээр сарын 11 өдөр урилгыг 1 багц болгон зарласан ба Үнэлгээний хороон хурлаар Грийнхимистри ХХК-ны илгээсэн тендер шалгарч захиалагчид зөвлөмж илгээж гэрээ байгуулах эрх олгогдсон.</p> <p>2. Эрүүл мэндийн сайдын А/299 тоот тушаал/ Төсөв баталж эрх шилжүүлэх тухай /Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үе, үер ус болон үерийн дараа үүсэж болзошгүй халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын ариутгал халдваргүйтгэлийн</p>	
--	---	--

		<p>бодисын бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай зардалд 210,097,500 төгрөгийн төсвийг баталсан.Төвийн захирлын А/46 тоот тушаалаар үнэлгээний хороог томилсон.Ариутгал халдваргүйтгэлийн бодис нийлүүлэх оролцогчийг сонгон шалгаруулах тендер нийт 3 багцтай зарласан.</p> <p>Багц 1-Ариутгалын бодис нийлүүлэх багцад 2 оролцогч материалаа ирүүлсэн Түвшинбилэг төгөлдөр ХХК –ний ирүүлсэн тендерээс татгалзсан үндэслэл нь оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг ирүүлээгүй үндэслэлээр хамгийн сайн тендерээр шалгараагүй.Реактив ХХК-ны ирүүлсэн тендер үнэлгээний хороон хурлаар хамгийн сайн тендерээр шалгарч захиалагчид зөвлөмж хүргүүлж гэрээ байгуулах эрх олгогдон.</p> <p>Багц-2 Халдваргүйтгэлийн бодис нийлүүлэх тендерт Гүн тэнгэрийн нар ХХК-ны ирүүлсэн тендер үнэлгээний хороон хурлаар шалгарч захиалагчид зөвлөмж хүргүүлсэн ба мөн гэрээ байгуулах эрх олгогдсон</p> <p>Багц-3-т Оролцогч шалгараагүй тендер амжилтгүй төлөвтэй байна.</p> <p>3. ЭМС-ын 2024 оны Жагсаалт батлах тухай А/165, А/200 дугаар тушаалын хавсралтад тусгагдсан эрүүл мэндийн байгууллагуудын туулах чадвар сайтай, түргэн тусламжийн автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах гэрээ байгуулах сунгах цуцлах хяналт тавих эрхийг А/226 тоот тушаалаар шилжүүлсэн 140,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн урилгыг 7 удаа зарласан боловч оролцогч байхгүй төлөвтэй байна.</p>	
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	Ингүүмэл жаргалант ХХК-тай гэрээ хийж санхүүгийн 3-р улирлаар тасалбар болгон худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байна одоогоор хяналт шалгалтын дүгнэлт эцэслэн гараагүй байна.	100
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, аргазүйн зөвөлгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Нээлттэй тендерийн үйл ажиллагаатай холбоотой сонирхогч этгээдүүдээс ирүүлсэн нэмэлт тайлбар тодруулга авах хүсэлтийг тухай бүр худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим сайт болох www.tender.gov.mn -ээр дамжуулан хариуг байршуулан ажилласан. Ингэснээр тухайн тендерийг сонирхогч аж ахуй нэгжүүдэд цахим сайтаар дамжуулан олон нийтэд ил тод, тэгш хүртээмжтэй байхаар ажилласан.	100
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Тайлангийн хугацаанд Дэлхийн банк, Цар тахлын сангаас санхүүжилттэй ажлыг НҮБ-ийн Хүүхдийн сан, ДЭМБ, АНУ-ын Флоридагийн Их Сургуулийн нийт 500 сая гаруй төгрөгийн төсөлт ажлуудыг хийлээ. Үүнд: 1. Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдсэн “Нэг эрүүл мэнд-Зооноз” үйл	100

		<p>ажиллагаа:</p> <p>2023 онд эхэлсэн “Монгол улсад нэг эрүүл мэндийн хандлага хэрэгжих таатай орчин бүрдүүлэх зөвлөх үйлчилгээ”-ний 234,567,322 (440,823,992) төгрөгийн төслийн ажлыг гурван чиглэлийн хүрээнд 2024 онд хийж дуусгалаа.</p> <p>2. ДЭМБ-ын санхүүжилтээр хийгдсэн “Шувууны томуугийн үнэлгээ, тандалт”-ний үйл ажиллагаа:</p> <p>Шувууны томуу өвчний тандалт, хариу арга хэмжээний салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд Зоонозын өвчин судалын үндэсний төв, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн баг дараах чиглэлээр хамтран ажиллаа.</p> <p>3. ДЭМБ-ын санхүүжилтээр хийгдсэн ““Монгол дахь уйланхайт бэтэг өвчний эмнэлзүйн удирдамжийг сайжруулах болон Нэг эрүүл Мэнд зарчимд уялдуулах нь”” үйл ажиллагаа:</p> <p>Энэхүү төсөлт судалгааны хүрээнд Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төвийн Статистикийн тасгаас бэтэг өвчнөөр хэвтэн эмчлүүлэгсдийн нийт тоо мэдээлэлийг түүвэрлэх,</p> <p>Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг (УНТЭ), Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг (УГТЭ), Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн (ЭХЭМҮТ) эмнэлэгүүдийн архивийн мэдээллээс бэтэг өвчнөөр хэвтэн эмчлүүлсэн өвчтнүүдийн өвчний түүхийг цуглуулж, дүн шинжилгээ хийх,</p> <p>Бэтэг өвчний талаар эмч мэргэжилтнүүдээс асуумж, ярилцлага судалгааг авах</p> <p>Цуглуулсан нийт мэдээлэлд дүн шинжилгээ хийж эмнэлзүйн удирдамжийг хэрхэн сайжруулах зөвлөмж, газар зүйн эрсдлийн үнэлгээг боловсруулах ажлууд хийгдэж байна.</p> <p>4. Цар тахлын сангаар хийгдсэн үйл ажиллагаа:</p> <p>Дэлхийн банкны Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний санхүүжилтийн шинэ зуучлалын сангийн 15.4 сая ам. дол буюу 52 тэрбум төгрөгийн санхүүжилттэй “Монгол улсын цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг Нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх нь 2024-2026 он” төслийг ЗӨСҮТ-ээс хийх ажлуудаас дараах сургалтудыг зохион байгуулаад байна.</p> <p>4.1 “Сорилын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандарт” шаардлага таниулах сургалтад Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, мэргэжилтэн хамрагдах тухай албан тоот Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлэн гэрээ хийсэн.</p>	
--	--	---	--

		<p>Энэхүү гэрээний дагуу “Сорилын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандарт” таниулах сургалтад ЗА, ЛЛА, ЧАБХҮА, НЭМТШУА, ЭШСМТА нийт 5 албаны 35 эмч мэргэжилтэнүүд хамрагдан сертификат авсан.</p> <p>5. АНУ-ын Флоридагийн их сургуультай хамтарсан “Монгол орны эктопаразит ба эктопаразитаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгаа” сэдэвт судалгааны төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Монгол орны эктопаразит ба эктопаразитаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгаа” (хугацаа 2024-2025, судалгааны санхүүжилт 34,000\$), “Малчдын хачгаар дамжих халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх нь” (хугацаа 2024-2025, судалгааны санхүүжилт 2500\$) сэдэвт 2 судалгааны арга зүйг төвийн дэргэдэх эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж, “Малчдын хачгаар дамжих халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх нь” судалгааг эхлүүлэх зөвшөөрлийг авсан. Тус судалгааг 2025 оны нэгдүгээр улиралд гүйцэтгэнэ. Мөн Монгол орны эктопаразит ба эктопаразитаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгааны хүрээнд 4 удаагийн тандалт судалгаагаар 6 аймгийн нутаг дэвсгэрийг хамруулан 3 зүйлийн 1830 хачиг цуглуулсан. Цуглуулсан хачгуудад хачгаар дамжих халдварын үүсгэгч илрүүлэх молекул биологийн судалгаа үргэлжлэн хийгдэж байна. Сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг ЭМЯамаар баталгаажуулж www.shilendans.gov.mn сайт болон төвийн www.nczd.gov.mn сайтуудад байршуулан ажилласан.</p>	
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	<p>Нийслэлийн мал эмнэлгийн газартай хамтран Малын эмч нарын дунд мэргэжлээс шалтгаалах бруцеллөз өвчний эрсдэлийг үнэлж, халдваржилтийг тогтоох зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн 10 гаруй байгууллагын 53 мэргэжилтнийг тандалт судалгаанд хамруулав.</p> <p>Судалгаанд оролцогчдын 42% нь 10-аас дээш жил мал эмнэлэгийн салбарт ажилласан, 21% нь 5-10 хүртэлх жил ажилласан, 13,5% нь 1 жил ажилласан, 9.6% нь 1-5 жил ажилласан байна. Асуумж судалгаагаар малын эмч нарын 98% нь бруцеллөз өвчнөөр өвчилж байгаагүй гэж хариулсан ч бидний хийсэн лабораторын шинжилгээгээр 9.4% (5 хүн) бруцеллөз өвчний халдвартай байгааг (В.Abortus) тогтоолоо.</p>	100
3.15	Хууль тогтоомжид заасан бусад	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг сар бүр Хүний	100

		нөөцийн менежер www.shilendans.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.	
Хэсгийн дундаж хувь:			100
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал			
4.1	Үзүүлж байгаа үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Төв төрийн сан банкны үндсэн 100900020021, нэмэлт санхүүжилтийн 100900020413 тоот дансаар төлбөр тооцоо гүйцэтгэгдэж байна.	100
4.2	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл: - Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх ТХ23/23/0010, 2026 оны 8 дугаар сарын 17-өдөр хүртэл хүчинтэй. - Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох ХХ 23/24/0154 дугаартай, 2026 оны 8 дугаар сарын 18-өдөр хүртэл хүчинтэй. - Тусгай зөвшөөрөл эзэмжишч: ЗӨСҮТ Нэр: Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, ашиглах - Гэрчилгээний дугаар: №0000004. - Хүчинтэй хугацаа: 2024.08.08-2029.08.08 - Тусгай зөвшөөрөл эзэмжишч: ЗӨСҮТ Нэр: Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, ариутгал - Гэрчилгээний дугаар: №0004639 - Олгосон: 2018.04.24 - Сунгуулсан: 2021.04.24 - Хүчинтэй хугацаа: 2026.04.24 	100
Хэсгийн дундаж хувь:			100
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Засгийн газрын 2023 240, 241 дүгээр тогтоолд нэмэлт орохтой холбоотойгоор Зоонозын салбарын амьтан сувланч, шимэгч судлагч, генетикч, малын эмч, биотехнологич, биохимич, амьтан маллагч гэсэн албан тушаалыг “ТҮЭМ-5” ангилал зэрэглэлд оруулах үндэслэл бүхий хүсэлийг тТөрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Дээрх асуудлаар Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны гауу гомдол саргасан албан хаагч нарын албан тушаалыг	100

		“ТҮЭМ-5” ангилал зэрэглэлд оруулах саналыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд Төрийн албаны зөвлөлийн гишүүний 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03/112 дугаар албан бичгээр хүргүүлсэн боловч тус албан бичгийн дагуу тайлбар ирээгүй байна.	
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн жагсаалт	<p>1.Адъяасүрэн З, Батсүх Д, Ален Б, Нарантуяа С. Тарваган тахлын ян цөлмүүр (М-99), шинэ бүтээл, патентын эрх хамгаалсан, гэрчилгээ №720, УБ, 1992.</p> <p>2.Адъяасүрэн З, Батсүх Д, Ален Б, Нарантуяа С. Хуурмаг сүрьеэгийн ян цөлмүүр (Ү 1504), шинэ бүтээл, гэрчилгээ №721, УБ, 1992.</p> 	100
5.3	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээ дугаар-0177723. Хаяг Улаанбаатар хот СХД,20 дугаар хороо. Талбай хэмжээ 56583 м2.	100
5.4	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бүтэц, дүрмийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/305 дугаар тушаалаар баталсны дагуу ажиллаж байна. Удирдлагын зөвлөлийн гишүүдийг томилохдоо ажилтан сонгон шалгаруулж авах журмын дагуу авч, Авлигатай тэмцэх газраар Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулан, зөрчил илрээгүй тохиолдолд албан тушаалд томилон ажиллуулдаг.	100

	мэдээлэл		
5.5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Төрийн өмчийг иргэн хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргах зэрэг шийдвэр гаргаагүй байна.	100
5.6	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	Манай байгууллагын зүгээс явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл судалгаа одоогоор байхгүй байна.	100
5.7	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	2024 онд шинээр барилга байгууламж бариагүй.	
5.8	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан тухайн хууль тогтоомжийн дагуу ямар нэгэн гэрээ хэлцэл байгуулах шаардлага байхгүй тул одоогоор гэрээ хийгдээгүй.	100
5.9	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу ЭМХТөвд Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол бүрийг https://burtgel.mohs.mn/appmenu программ хангамжид ЭМХТөвд хүргүүлж ажилласан.	100
5.10	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний	Төв нь гадаад хамтын ажиллагааны хүрээнд төсөл хөтөлбөрүүд санхүүжилтээр 4 улсад болон дотооддоо 17 удаагийн сургалтанд үндэсний төвийн болон нийслэл аймгийн ЗӨСТ-ийн 118 мэргэжилтнийг хамруулж дадлагажуулсан байна. Үүнээс: 1. ОХУ-тай хамтарсан төсөл хөтөлбөр-4 2. АНУ-тай хамтарсан төсөл хөтөлбөр-1	100

	хэрэгжилт	<p>3. БНХАУ-тай хамтарсан өөл хөтөлбөрийн зардлаар-3 тус тус хамрагдсан</p> <p>4. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зардлаар-3</p> <p>5. Дэлхийн банкний зардлаар-2</p> <p>6. НҮБ-н Хүүхдийн сангийн зардлаар-2</p> <p>7. БНСАУ-н КОИКО- ОУБ-н зардлаар-1</p> <p>8. Цөмийн инергийн комиссын зардлаар-1 тус тус хамруулсан байна.</p> <p>төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн зардлын тайланг холбогдох санхүүжүүлэгч байгууллагууд, ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газарт хяналт, шинжилгээ үнэлгээний тайлангийн маягтын дагуу улирал, жил бүрээр тайланг хүргүүлэж ажилладаг.</p>	
5.11	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад бүх мэдээллүүдийг ил тодоор байршуулж хэвшсэн	100
Хэсгийн дундаж хувь:			100
Хэрэгжилтийн дундаж хувь			99,8

ХЯНАСАН:
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АМГАЛАНБАЯР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

П.ЛХАГВАЦЭРЭН